

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

(Хамрах хугацаа: 2023.01.03-2023.12.12)

2023.12.12.

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлөөс 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу жилийн дүнгээр гүйцэтгэсэн ажлын товч тайланг танилцуулж байна.

Нэг. Сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгын талаар:

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд жилийн дүнгээр салбар зөвлөлөөс төрийн захиргааны гүйцэтгэх 28 албан тушаалын сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газарт албан бичгээр хүргүүлж, ажлын 10 хоног Төрийн албаны зөвлөлийн цахим сайтаар нийтэд зарлууллаа.

Хүснэгт-1

№	Захиалга хүргүүлсэн албан бичгийн огноо, дугаар	Сул орон тоо		Албан тушаалын нэр
		Удирдах албан тушаал	Гүйцэтгэх албан тушаал	
1	2023.01.09 №01		6	Өмнөд бүс дэх газрын захиргааны ахлах мэргэжилтэн-1; Дорноговь аймаг дахь газрын мэргэжилтэн-2; Зүүн бүс дэх газрын мэргэжилтэн-3.
2	2023.03.02 №02		2	Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн гадаад харилцааны мэргэжилтэн-1; Баруун бүс дэх газрын Увс аймаг дахь мэргэжилтэн-1.
3	2023.03.20 №03		2	Дорноговь аймаг дахь газрын мэргэжилтэн-1; Зүүн бүс дэх газрын мэргэжилтэн-1.
4	2023.05.09 №05		7	Хойд бүс дэх газрын Хөвсгөл аймаг дахь хэлтсийн ахлах мэргэжилтэн-1; Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн-1; Дорноговь аймаг дахь газрын мэргэжилтэн-2; Баруун бүс дэх газрын мэргэжилтэн-1; Зүүн бүс дэх газрын мэргэжилтэн-2.
5	2023.06.06 №06		5	Дорноговь аймаг дахь газрын мэргэжилтэн-2; Өмнөд бүс дэх газрын мэргэжилтэн-1; Зүүн бүс дэх газрын мэргэжилтэн-2.
6	2023.09.11 №07		6	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсийн хяналт шинжилгээ хариуцсан мэргэжилтэн-1; Өмнөд бүс дэх газрын мэргэжилтэн-1; Баруун бүс дэх газрын мэргэжилтэн-1; Зүүн бүс дэх газрын мэргэжилтэн-2; Баруун бүс дэх газрын Увс аймаг дахь хэлтсийн мэргэжилтэн-1.
7	2023.10.09 №08		4	Хойд бүс дэх газрын мэргэжилтэн-1; Зүүн бүс дэх газрын мэргэжилтэн-3.
8	2023.12.11 №09		4	Зүүн бүс дэх газрын мэргэжилтэн-3; Баруун бүс дэх газрын Увс аймаг дахь хэлтсийн мэргэжилтэн-1.
ДҮН		0	36	

Төрийн албаны тухай хуулийн 27.2, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.3.1, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам, загвар батлах тухай” 25 дугаар тогтоолоор баталсан журмын 4.2-т заасны дагуу 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дахь удаа 26 гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын зарыг төрийн жинхэнэ албан хаагчдын хүрээнд 5-аас доошгүй хоног байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудсаар “Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах зар”-ыг нээлттэй байршуулж байна.

Зарын дагуу албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан төрийн жинхэнэ албан хаагч бүртгүүлсэн тохиолдолд дээрх журмын дагуу нийтэд зарлахгүйгээр шууд томилохоор журмын зохицуулалттай болсон. Харин шаардлага хангасан төрийн жинхэнэ албан хаагч бүртгүүлээгүй бол ажлын 10-аас доошгүй хоног зарлах явцдаа бүртгэл нь хамт хийгдэж байна.

Хоёр. Албан тушаалын тусгай шалгалт зохион байгуулсан талаар:

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд 2023 онд салбар зөвлөлийн 01, 08, 11, 15, 21, 26, 34, 37 дугаар тогтоолоор байгуулсан сонгон шалгаруулалтын комисс байгуулж, төрийн захиргааны гүйцэтгэх 32 албан тушаалын сул орон тооны 7 удаагийн тусгай шалгалтыг зохион байгууллаа.

Тусгай шалгалтад тэнцсэн иргэдийн 4 буюу 12.5 хувь төрийн албанаас түр чөлөөлөгдсөн иргэдийн нөөцөд бүртгэлтэй, 12 буюу 37.5 хувь нь 2021-2023 оны төрийн албаны ерөнхий шалгалтын нөөцөд бүртгэлтэй иргэд, 5 буюу 15.6 хувь төрийн жинхэнэ албан хаагч, нээлттэй зарлуулсан 28 сул орон тооноос 11 буюу 34.3 хувь нөхөгдөөгүй.

Хүснэгт-2

№	Тусгай шалгалт зохион байгуулсан огноо	Тоо		Сул орон тоог		Тайлбар
		Удирдах албан тушаал	Гүйцэтгэх албан тушаал	Нөхсөн	Нөхөөгүй	
1	2023.02.10		6	4	2	Шаардлага хангасан иргэн бүртгүүлээгүй
2	2023.03.27		2	2		-
3	2023.04.28		2	2		-
4	2023.05.29		7	4	3	Бүртгүүлэх хүсэлт ирээгүй
5	2023.06.29		5	2	3	Босго оноо хүрээгүй 2, бүртгүүлэх хүсэлт ирээгүй 1
6	2023.10.04		6	6		-
7	2023.11.09		4	1	3	Шаардлага хангасан иргэн бүртгүүлээгүй
ДҮН		-	32	21	11	

Тухайн албан тушаалын буюу тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн hh-admin.csc.gov.mn цахим системээр зохион байгуулж, сонгон шалгаруулалтын захиалга, зар оруулах, бүртгэх, шалгалт авах, дүнг мэдээлэх бүх үйл явц цахимаар явагдаж хэвшсэн.

Гурав. Бусад үйл ажиллагааны талаар:

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланг Төрийн албаны тухай хуулийн 74.1 дэх хэсэг, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийн дагуу нэгтгэн, байгууллагын даргын 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01/29 албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газарт хугацаанд нь хүргүүлэв.

Салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт жилийн дүнгээр 98.2 хувьтай. Эхний хагас жилийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны нэгдсэн тайланг байгууллагын даргын 06 дугаар сарын 26-ны өдрийн 01/1073 албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газар хүргүүлэв. Жилийн эцсийн тайланг “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасны дагуу ирэх 1 дүгээр сарын 15-ны дотор хүргүүлэх юм.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” журамд заасан төрийн алба хаасан хугацаа, тухайн ангилалд ажилласан жил, 2022 оны ажлын гүйцэтгэлийн үнэлгээг харгалзан зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох шаардлага хангасан албан хаагчдын судалгааг боловсруулж, 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01-02/08 илтгэх хуудсаар байгууллагын удирдлагад танилцуулж, ахлах, дэс түшмэлийн зэрэг дэв олгуулах саналыг ГИХГ-ын 02 дугаар сарын 02-ны өдрийн 01/225 албан бичгээр ХЗДХЯ-д, эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийн саналыг 02 дугаар сарын 17-ны өдрийн 01/303 албан бичгээр Монгол Улсын Төрийн албаны зөвлөлд тус тус хүргүүлж, шаардлага хангасан албан хаагчдаас ахлах түшмэлийн дөтгөөр 2, дэс түшмэлийн тэргүүн 19, дэд 17, гутгаар 7, дөтгөөр 14, эрхэлсэн түшмэлийн дэд 2, дөтгөөр зэрэг дэвийг 1, нийт 63 албан хаагчид зэрэг дэв шинээр болон ахиулан олгууллаа.

Хүснэгт-3

	Тэргүүн түшмэл	Эрхэлсэн түшмэл		Ахлах түшмэл	Дэс түшмэл				Дүн
	Дөтгөөр зэрэг	Дэд зэрэг	Дөтгөөр зэрэг	Дөтгөөр зэрэг	Тэргүүн зэрэг	Дэд зэрэг	Гутгаар зэрэг	Дөтгөөр зэрэг	
Шинээр	1	-	1	2	-	-	-	14	18
Ахиулах	-	2	-	-	19	17	7	-	45
НИЙТ									63

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 06 дугаар сарын 06-ны өдрийн 63 дугаар зарлигаар тэргүүн түшмэлийн дөтгөөр зэрэг дэв 1, Засгийн газрын 2023 оны 410 дугаар тогтоолоор эрхэлсэн түшмэлийн дэд зэрэг дэв 2, дөтгөөр зэрэг дэв 1, нийт 4 удирдах албан тушаалтанд тус тус зэрэг дэв олгууллаа. Үүний дүнд байгууллагын хэмжээнд төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвтэй албан хаагчид 147 буюу 77.7 хувийг эзэлж, өмнөх оноос 2.5 хувиар өссөн үзүүлэлттэй.

Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-д 2022 оны “Журамд өөрчлөлт оруулах тухай” 491 дүгээр тогтоолоор төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тооцох аргачлалд өөрчлөлт орсонтой холбогдуулан Нийт 256 албан

хаагчдын төрийн алба хаасан хугацааны судалгааг шинэчлэн, давхардсан тоогоор 298 албан хаагчид нэмэгдлийг байгууллагын даргын тушаалаар сар бүр шинэчлэн тогтоож байна.

Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох журам”-ын дагуу төвийн нэгжийн төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг улирлаар үнэлж, ур чадварын нэмэгдлийг нийт 4 удаагийн байгууллагын даргын Б/05, Б/105, Б/179, Б/289 дүгээр тушаалаар, давхардсан тоогоор 131 төрийн үйлчилгээний албан хаагчдад 10-25 хувийн нэмэгдлийг олгуулсан.

Мөн Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоолын дагуу төрийн захиргааны албан хаагчдын ангилал, зэрэглэлийг байгууллагын даргын 01 дүгээр сарын 26-ны өдрийн Б/26 дугаар тушаалаар, мөн “Төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын дагуу байгууллагын даргын 07 дугаар сарын 05-ны өдрийн Б/226 дугаар тушаалаар дагуу төв, орон нутаг дахь нэгжийн төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын цалинг тус тус шинэчлэн тогтоосон. Тайлант хугацаанд Засгийн газрын тогтоолын дагуу 01, 07 дугаар сард цалинг шинэчлэн тогтоосон төрийн захиргааны болон үйлчилгээний 202, зэрэг дэв ахиулсан, шинээр авсан 63, цалинг итгэлцүүрээр шинэчлэн тогтоосон 3, нийт давхардсан тоогоор 914 албан хаагчийн мэдээллийг тухай бүр шинэчилсэн.

Хүснэгт-4

№	Төрөл	Албан хаагч	Хувь
1	Төрийн үйлчилгээний албан хаагчийн ур чадварын нэмэгдэл	131 /давхардсан/	10-25
2	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл	298	1-25
3	Улирлын мөнгөн урамшуулал	209	30-40
4	Илүү цагийн нэмэгдэл хөлс	8	-
5	Нийт албан хаагчдын албан тушаалын цалин	202	
6	Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдэл	63	
7	Цалинг итгэлцүүрээр шинэчлэн тогтоосон	3	
Нийт		914 /давхардсан тоо/	

Тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн энэ оны 22, 36 дугаар тогтоолоор 07 дугаар сарын 07 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 27-ны өдрүүдэд төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын үйл ажиллагааг 2 удаа байгууллагын хүндэтгэлийн танхим, орон нутаг дахь газруудад ёслол төгөлдөр зохион байгуулж, төрийн албанд шинээр томилогдсон 14 албан хаагч, мөн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу хяналтын улсын байцаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг 1 удаа зохион байгуулж, 7 хяналтын улсын байцаагч хамрагдав.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛ**

